

2019-2020 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ  
ДҮҮРГИЙН МАТЕМАТИКИЙН ОЛИМПИАДЫН УДИРДАМЖ

2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Зорилго: Сурагчдын сэтгэн бодох чадвар, сэтгэлгээний хурдыг нэмэгдүүлэх, ой тогтоолт, оюуны чадамжийг сайжруулах, нийслэл болон улсын математикийн олимпиадад оролцох багш, сурагчдыг сонгон шалгаруулахад оршино.

**НЭГ. ДҮҮРГИЙН ОЛИМПИАД**

- Дүүргийн олимпиадад төрийн болон төрийн бус өмчийн сургуулиас шалгарсан 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дугаар ангийн ердийн сургалттай сургуулиас 3 сурагч, гүнзгийрүүлсэн сургалттай сургуулиас 5 сурагч оролцуулна.
- Сүхбаатар дүүргийн хувьд хот, улсын олимпиадад тогтмол амжилттай оролцдог сургуулиуд нь харилцан зөвшилцсөний үндсэн дээр дээр дурдсан тооноос илүү тооны сурагч оролцуулж болно. Энэ тохиолдолд сурагчдын тоог нэмсэнтэй холбогдон гарах зардлыг сурагчдаа нэмж оролцуулсан сургуулиуд хариуцна.
- Сурагч анги дэвшиж оролцохыг зөвшөөрөх ба энэ тохиолдолд уг сурагчийг дэвшиж орсон ангийн сурагч гэж үзнэ. Өөрөөр хэлбэл дэвшиж орсон ангилалд зөвшөөрөгдсөн тооноос олон сурагч оролцохгүй гэсэн үг.
- Сургууль бүрээс бага, дунд ангийн тус бүр 3-5 багш оролцоно.
- Дүүргийн олимпиадыг Боловсролын хэлтэс мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, материал засах багш нарын баг, ахлагчийг томилон ажиллуулна.
- Дүүргийн Боловсролын хэлтэс, олимпиад зохион байгуулах сургуультай хамтран удирдамж гаргаж, бүртгэлийн ажлыг зохион байгуулна.
- Олимпиадын сэдвийг дүүрэг дээр ажиллах комиссын ахлагч 2019 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 08:00 цагт ирж, НБГ-ын судлагдахуун хариуцсан мэргэжилтнээс авна.
- Монголын математикийн олимпиадын хорооны гишүүдээс дүүрэгт урилгаар ажиллуулж болно. Энэ тохиолдолд холбогдох зардлыг зохион байгуулагч хариуцна.
- Олимпиадтай холбоотой маргаантай асуудлыг тухайн дүүргийн комисс эцэслэн шийдвэрлэнэ.
- Олимпиад зохион байгуулсан талаарх тайлан, мэдээг гаргаж 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдөр [boldbaatar@edub.edu.mn](mailto:boldbaatar@edub.edu.mn) хаягаар ирүүлнэ.
- Дүүргийн олимпиад 2019 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 10:00 цагаас доорх сургуулиуд дээр зохион байгуулагдана.

**ДҮҮРГИЙН МАТЕМАТИКИЙН ОЛИМПИАД ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ**

№	Дүүрэг	Зохион байгуулах сургууль
1	Баянзүрх	21 дүгээр сургууль
2	Баянгол	Оюуны-Ундраа цогцолбор сургууль
3	Чингэлтэй	17 дугаар сургууль
4	Сонгинохайрхан	Ирээдүй ЦС-2 ахлах сургууль
5	Хан-Уул	52 дугаар сургууль
6	Сүхбаатар	1 дүгээр сургууль
7	Налайх, Багануур, Багахангай	119 дүгээр сургууль

**ХОЁР. НИЙСЛЭЛИЙН ОЛИМПИАД**

- Дүүргийн математикийн олимпиадаас VII-XII ангийн ангилалд дүүрэг бүрээс эхний 10 байр, "УВ" оноо авч шалгарсан сурагчид болон хотод оролцох эрх авсан бага, дунд ангийн багш нар нийслэлийн олимпиадад оролцоно. Сурагчид хувиараа орохгүй. Оролцогч бүр нэг ангилалд оролцоно.
- Нийслэлийн олимпиадыг БСШУСЯ-аас ирүүлсэн хуваарийн дагуу Улаанбаатар хотод нэгдсэн байдлаар зохион байгуулна.